



35 жилийн туршалд
өөрчлөлт оруулсан

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 270

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах, тушаалд
өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”, “Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлаар санал боловсруулах зөвлөл”-ийн 2007 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэл, Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагуудын саналыг тус тус ундэслэн ТУШААХ нь:


1. Буджав овогтой Бат-Отгоныг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар АНУ-ын Жоржтаун их сургуулийн магистрантурт төрийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Гонгорсүрэн овогтой Лхамсүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар АНУ-ын Калифорнийн улсын их сургуулийн магистрантурт олон улсын эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Ганболд овогтой Мөнхчимэгийг Эрүүл мэндийн яамны захиалгаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Кингстон их сургуулийн докторантурт эм зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Дашдорж овогтой Наранжаргалыг Эрүүл мэндийн яамны захиалгаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Ноттингамын их сургуулийн докторантурт дүрслэл оношлогооны чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Төртогтох овогтой Сармандахыг Улсын мэргэжлийн хяналтын газрын захиалгаар Австрали улсын Бонд их сургуулийн магистрантурт бизнесийн чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Мягмарсүрэн овогтой Батгэрэлийг Сангийн яамны захиалгаар АНУ-ын Фонтбонн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Пүрэвжав овогтой Сайнзоригийг Байгаль орчны яамны захиалгаар АНУ-ын Өмнөд Каролайны их сургуулийн магистрантурт байгаль орчны эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Амарсанаа овогтой Амарбаярыг АНУ-ын Норд Дакота мужийн Дикинсоны улсын их сургуульд мэдээллийн технологийн чиглэлээр, Агваанцэрэн овогтой Энхтайваныг АНУ-ын Пенсильванийн Эдинборо их сургуулийн магистрантурт симфони оркестрын удирдаач, дуурийн найруулагчийн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

3. Сингапур улсын Raffles академийн магистрантурт удирдлагын чиглэлээр суралцаж буй Дүгэрхүү овогтой Уянгын суралцах хугацааг 0.5 жилээр сунгасугай.

4. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 192 дугаар тушаалын Бадарчин овогтой Эрдэнэбаттай холбогдолтой хэсгийн "Австрали улсын Жеймс Күүкийн их сургуулийн магистрантурт" гэснийг "Австрали улсын Ньюкастл их сургуулийн магистрантурт" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 225 дугаар тушаалын Эрдэнээ овогтой Батзоригтой холбогдолтой хэсгийн "Австрали улсын Мельбурний их сургуулийн магистрантурт" гэснийг "Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондонгийн Бизнес, санхүүгийн сургуулийн магистрантурт" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 312 дугаар тушаалын "Япон улсын Нагаокагийн их сургуулийн магистрантурт" гэснийг "АНУ-ын Калифорнийн Олон улсын их сургуулийн магистрантурт" гэж тус тус өөрчилсүгэй.

5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн-/д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



САЙД

θ.ЭНХТУВШИН

θ.ЭНХТУВШИН